



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/679

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2228, Их Монгол Улсын 813, Ардын хувьсгалын 98, Нийслэлийн 380 жилийн ойн Үндэсний их баяр наадмын хүндэтгэлийн концертын бэлтгэл ажлыг хангах үүднээс Нийслэлийн Соёлын төв өргөөний дууны тоног төхөөрөмжийг шинэчлэх, засварлах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Дарга: -Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч
- Гишүүд: -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /зөвшилцсөнөөр/
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга
- Нийслэлийн Соёлын төв өргөөний захирал
- Нарийн бичгийн дарга: -Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

2.Нийслэлийн Соёлын төв өргөөний дууны тоног төхөөрөмжийг шинэчлэх, засварлах ажлыг зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Ж.Батбаясгалан/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

111070003243